



“ТЭТГЭВРИЙН УУГАН САН” ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 10 сарын 17-ны өдөр

Дугаар 17/04

Улаанбаатар хот

“Тэтгэврийн ууган сан ТББ-ын гишүүнчлэлийн журам” батлах тухай

Төрийн бус байгууллагын тухай хуулийн 11.1, Тэтгэврийн ууган сан ТББ-ын дүрмийн 4.8.9, Удирдах зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Тэтгэврийн ууган сан ТББ-ын гишүүнчлэлийн журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журам батлагдсантай холбоотойгоор сангийн гишүүдийн хуримтлалын мэдээллийг шүүж 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх төлөгдөөгүй гишүүний хураамжийг тооцож сангийн орлого болгосугай.
3. Хуримтлал нь хураамжид суутгагдаж дууссан идэвхгүй гишүүдийн тайланг гаргаж Гишүүний нэрийн данс хаах акт үйлдэн сангийн гишүүнчлэлээс хассугай.
4. Дээр дурдсан ажлыг 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн дотор хийхийг Гүйцэтгэх захирал /Ж.Хишигжаргал/ -д үүрэг болгосугай.
5. Тогтоолын нэг хувийг Хяналтын зөвлөлийн дарга /С.Төгсбилэг/-т хүргүүлсүгэй.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



О.ГАНЖОЛОО



“ТЭТГЭВРИЙН УУГАН САН” ТББ-ЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам нь “Тэтгэврийн ууган сан” ТББ-д (цаашид Сан гэх) гишүүнд тавигдах шаардлага, гишүүнийг бүртгэх, нэрийн данс нээх, гишүүнчлэлийн хугацааг тооцох, бүртгэлээс хасах, мэдээ мэдээлэл солилцох, гишүүний эрх, үүрэгтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү харилцаанд Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Тэтгэврийн Ууган Сан ТББ-ын дүрэм, Үйл ажиллагааны ерөнхий журам, Удирдах зөвлөлийн тогтоол шийдвэр, Гишүүн байгууллагатай хийсэн гэрээ болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.3 Энэхүү журмыг Сангийн Удирдах зөвлөл батална. Журамд оруулах нэмэлт өөрчлөлт нь мөн энэ заалтын дагуу батлагдана.

Хоёр. Журамд хэрэглэгдэх нэр томьёо

- 2.1 Энэхүү журамд дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 2.1.1 “гишүүн байгууллага” гэж сантай гэрээ байгуулж, санд хуримтлал оруулж буй ажил олгогчийг;
 - 2.1.2 “ажилтан гишүүн” гэж сантай гэрээ байгуулж санд хуримтлал оруулж буй гишүүн байгууллагын үндсэн ажилтныг;
 - 2.1.3 “хувь гишүүн” гэж сантай гэрээ байгуулж, санд хуримтлал оруулж буй иргэнийг;
 - 2.1.4 “гишүүн” гэж ажилтан гишүүн болон хувь гишүүнийг хамтад нь;
 - 2.1.5 “хөрөнгө оруулалтын багц” гэж сангийн Хөрөнгө оруулалтын бодлогын дагуу идэвхтэй хэлбэрээр байршуулж буй төрөл бүрийн хөрөнгө оруулалтаас бүрдэх нийт хөрөнгийг;
 - 2.1.6 “идэвхгүй гишүүн” гэж өвчтэй болон чөлөөтэйгөөс бусад тохиолдолд гэрээнд заасан хугацаанаас хойш 6 сар хуримтлал хийгээгүй, энэ журмын 4.4.6-д заасан үүргээ биелүүлээгүйгээс холбоо барих боломжгүй болсон гишүүнийг.

Гурав. Гишүүнд тавигдах шаардлага, гишүүнийг бүртгэх, нэрийн данс нээх

- 3.1 Сангийн гишүүнээр элсэхэд тавигдах шаардлага:
 - 3.1.1 сангийн зорилго, үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч дэмжиж, сайн дураараа элсэх хүсэлтэй, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн байх;

- 3.1.2 ажилтан гишүүнээр элсэх хүсэлтэй иргэн нь сантай хамтран ажиллах гэрээ байгуулсан гишүүн байгууллагын үндсэн ажилтан байх;
- 3.1.3 хувь гишүүн сантай 3-аас доошгүй жилээр гэрээ байгуулж, хуримтлал оруулахыг зөвшөөрсөн байна. Хувь гишүүн гэрээ дуусгавар болгох хүсэлт гаргаагүй тохиолдолд гэрээг дахин 3 жилээр сунгасанд тооцно.
- 3.2 Энэ журмын 3.1-т заасан шаардлагуудыг хангасан иргэн нь сантай “Тэтгэврийн хуримтлалын гэрээ” (цаашид Гэрээ гэх) байгуулж сангийн гишүүн болно.
- 3.3 Гишүүн сантай гэрээ байгуулахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:
 - 3.3.1 цахим үнэмлэхний хуулбар.
- 3.4 Гэрээ батлагдмагц сангийн санхүү хариуцсан ажилтан гишүүнийг ТУС програмд бүртгэж, тэтгэврийн хуримтлалын нэрийн дансыг нээнэ.
- 3.5 Сангаас гишүүнд гишүүний дугаар, сангийн албан ёсны цахим хуудсанд нэвтрэх нэр, нууц кодыг гишүүний гэрээнд бүртгэлтэй и-мэйл хаягаар илгээнэ.

Дөрөв. Гишүүний эрх, үүрэг

- 4.1 Гишүүн дараах эрхтэй:
 - 4.1.1 сангаас өөрийн тэтгэврийн нэрийн дансан дахь хуримтлалын дансны үлдэгдэл, мэдээ судалгаа, тайланг гаргуулж авах, алдаа зөрүү илэрсэн гэж үзвэл энэ тухай сангийн холбогдох ажилтанд мэдэгдэж залруулах, тайлбар авах;
 - 4.1.2 сангийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, байгууллагын болон хувь хүний нууцад хамаарахаас бусад үйл ажиллагааны тайлан авах;
 - 4.1.3 сангийн Хөрөнгө оруулалтын бодлогын дагуу санал болгож буй багцуудаас сонгох замаар сангийн хөрөнгө оруулалтад оролцох;
 - 4.1.4 сангийн дүрэмд заасны дагуу бүх гишүүдийн хуралд оролцох, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох, сонгогдох, санал өгөх;
 - 4.1.5 санг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;
 - 4.1.6 хууль тогтоомж болон хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу нэг сараас хоёр жил хүртэлх хугацаагаар өвчтэй байх, чөлөө авах тохиолдолд мөн хугацаанд хуримтлал хийхгүй байж болох ба нэрийн дансан дахь хуримтлалд өгөөж авах;
 - 4.1.7 өөрийн хуримтлал болон түүнд ногдох өгөөжийг гуравдагч этгээдэд өвлүүлэх эрхтэй.
- 4.2 Ажилтан гишүүн дараах тусгайлсан эрхтэй:
 - 4.2.1 сангаас гарахдаа Хуримтлал буцаан олгох журам болон хамтран ажиллах гэрээнд заасны дагуу гишүүн байгууллагаас гишүүний тэтгэврийн нэрийн дансанд хуримтлуулсан мөнгөн хөрөнгө болон түүнд ногдох өгөөжөөс хувь хүртэх;
 - 4.2.2 гишүүн байгууллагатай хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон тохиолдолд санд хувь гишүүнээр элсэх.
- 4.3 Хувь гишүүн дараах тусгайлсан эрхтэй:
 - 4.3.1 хуримтлал хийх давтамжийг сар, улирал, хагас жилээр сонгох;
 - 4.3.2 өөрийн хуримтлал хийх хэмжээг сонгох.
- 4.4 Гишүүн дараах үүрэгтэй:
 - 4.4.1 гэрээнд заасан хугацаанд тохиролцсон хувь, хэмжээгээр нэрийн дансандаа хуримтлал хийх;
 - 4.4.2 гишүүний хураамжийг сар бүр санд төлөх;

- 4.4.3 Хөрөнгө оруулалтын бодлогын дагуу санд бүртгэлтэй и-мэйл хаягаар болон сангийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан хөрөнгө оруулалтын багц сонголт хийх;
- 4.4.4 гишүүн нэг сараас хоёр жил хүртэлх хугацаагаар өвчтэй байх, чөлөө авах тохиолдолд санд энэ тухайгаа урьдчилан цахимаар эсвэл бичгээр мэдэгдэх;
- 4.4.5 сангийн албан ёсны цахим хуудсанд нэвтрэх нэр, нууц код, өөрийн и-мэйл хаягийн нууцыг чандлан хадгалах;
- 4.4.6 гишүүний гэрээнд бүртгэлтэй холбоо барих утас, цахим хаяг, гэрийн хаяг, яаралтай үед холбоо барих хүний утас, хаяг өөрчлөгдсөн тохиолдолд санд нэн даруй и-мэйлээр эсвэл бичгээр мэдэгдэх;
- 4.4.7 4.4.3 – 4.4.6–д заасан үүргээ хэрэгжүүлээгүйгээс үүсэх эрсдэлийг гишүүн дангаараа хариуцна;
- 4.4.8 хуримтлал болон түүнд ногдох өгөөжийг буцаан авахдаа Монгол улсын хууль тогтоомжийн дагуу холбогдох татвар, хураамжийг төлөх үүрэгтэй;
- 4.4.9 гишүүн нь Монгол улсын хууль тогтоомжийг сахин биелүүлж, сангийн зорилгыг хүндэтгэн, сангийн холбогдох дүрэм журмыг баримтална.

Тав. Сангийн эрх, үүрэг

- 5.1 Сан дараах эрхтэй:
- 5.1.1 гишүүний хуримтлалын үнэ цэнийг бууруулахгүй байх, өгөөжөөр өсгөх зорилгоор хөрөнгө оруулалтын бодлогын дагуу хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах;
- 5.1.2 гишүүнийг гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг шаардах;
- 5.1.3 сангийн үйл ажиллагааг сайжруулах, гишүүдийн эрх ашиг, гишүүдийн хуримтлалыг эрсдэлээс хамгаалах зорилгоор шинээр дүрэм журам боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах;
- 5.1.4 гишүүний хуримтлалыг буцаан олгохдоо төлөгдөөгүй хураамжийг суутгаж авах;
- 5.1.5 Идэвхгүй гишүүний өгөөжийг тооцох бөгөөд төлөгдөөгүй гишүүний хураамжийг санхүүгийн жилийн эцэст өгөөж тооцсоны дараа гишүүний хуримтлалаас суутгаж авах бөгөөд гишүүний хуримтлал дууссан тохиолдолд Гишүүний нэрийн данс хаах акт үйлдэн гишүүний дансыг хаана.
- 5.2 Сан дараах үүрэгтэй:
- 5.2.1 сангийн гишүүн тус бүрийн нэр дээр тэтгэврийн нэрийн данс хөтөлнө.
- 5.2.2 сангийн хуримтлалын үнэ цэнийг хадгалах, эрсдэл өгөөжийн зохистой түвшинд хөрөнгө оруулалтыг удирдаж, өсгөх;
- 5.2.3 сан гишүүдэд өөрийн нэрийн дансан дахь хуримтлал, түүнд ногдох өгөөжийг цахим хэлбэрээр харах нөхцөл бололцоог бүрдүүлэх;
- 5.2.4 сан өөрийн цахим хуудсаар гишүүдэд сангийн үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээ, мэдээллийг тогтмол хүргэх;
- 5.2.5 гишүүний нэрийн дансны аливаа мэдээллийг хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд гишүүний зөвшөөрөлгүй бусдад задруулахгүй байх;

5.2.6 ажилтан гишүүнд ажил олгогчоос олгох хуримтлалыг Хуримтлал буцаан олгох журам болон гишүүн байгууллагатай хийсэн гэрээнд заасан хувь хэмжээгээр тооцож олгох;

5.2.7 гишүүнд хуримтлал буцаан олгохдоо Монгол улсын хууль тогтоомжийн дагуу холбогдох татвар, хураамжийг суутгаж, харьяа төрийн санхүү, татварын албанд шилжүүлэх;

Зургаа. Гишүүний хураамж

6.1 Сангийн үйл ажиллагааны зардалд зориулж Удирдах зөвлөлөөс гишүүний хураамжийн хэмжээг батална.

6.2 Гишүүн нь сар бүр гишүүний хураамжийг санд шилжүүлнэ.

6.3 Сан төлөгдөөгүй гишүүний хураамжийг санхүүгийн жилийн эцэст өгөөж тооцсон хуримтлалаас нөхөж суутгана.

6.4 Өвчтэй, чөлөөтэй, идэвхгүй байх хугацаа нь гишүүний хураамж төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

6.5 Хувь гишүүн нь гэрээнд заасан хуримтлал хийх давтамжаас хамааран гишүүний татварыг урьдчилж төлж болно.

Долоо. Мэдээлэл дамжуулах

7.1 Гишүүн нь сангаас доорх ажилбарын дагуу, мэдээ судалгаа, тайланг хүлээн авна:

7.1.1 сангийн цахим хуудсанд өөрийн нэвтрэх нэр, нууц үгээр нэвтэрч сангийн үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээлэл, тайланг авна.

7.1.2 сангийн цахим хуудсан дахь данс шалгах хэсэгт гишүүний дугаар, эсвэл и-мэйл хаяг, нууц кодыг оруулан өөрийн нэрийн дансан дахь тэтгэврийн хуримтлалын мэдээллийг авна.

7.1.3 санд бүртгэлтэй и-мэйл хаягаар эсвэл бичгээр сантай холбоотой санал, хүсэлтээ илгээж, хариу авах ба сангийн үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн болон шуурхай мэдээ мэдээллийг авна.

Найм. Гишүүнчлэлийн хугацаа ба ангилал

8.1 Дараах нөхцөлд гишүүнчлэлийн хугацааг эхэлсэнд тооцно:

8.1.1 Тэтгэврийн хуримтлалын гэрээ байгуулж, хоёр тал гарын үсэг зурж баталгаажсан өдрөөр;

8.1.2 гишүүнээр дахин элссэн тохиолдолд, гишүүний гэрээг шинээр байгуулах ба хоёр тал гарын үсэг зурж баталгаажсан өдрөөр,

8.2 Ажилтан гишүүн нь хууль тогтоомж болон хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу 3 /гурван/ сараас дээш хугацаагаар өвчтэй байх, чөлөө авахад гишүүнчлэлийг хэвээр хадгална.

8.3 Гишүүнчлэлийн хугацааг дараах нөхцөл болон өдрөөр дуусгавар болсонд тооцно:

8.3.1 үндсэн нөхцөл буюу гишүүн хуульд заасан өндөр насны тэтгэврийн насанд хүрч сангаас гарах хүсэлтээ ирүүлсэн огноогоор; (гишүүн нь тэтгэврийн насанд хүрснээс хойш гишүүн байгууллагад ажилд орсон тохиолдол хамаарахгүй)

- 8.3.2 хүндэтгэн үзэх нөхцөл буюу гишүүн тэтгэвэрт гарах насанд хүрэхээс өмнө эсвэл хүрснээс хойш нас барсан, хөдөлмөрийн чадвараа бүрэн (70 ба түүнээс дээш хувиар) алдсан акт баримтыг үндэслэн хүсэлт гаргасан огноогоор;
- 8.3.3 ажилтан гишүүний хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон тушаалд заасан огноогоор;
- 8.3.4 гишүүн сангийн гишүүнчлэлээ цуцлах хүсэлт гаргасан өргөдлийн огноогоор;
- 8.3.5 гишүүн байгууллага сантай байгуулсан гэрээг дуусгавар болгосон огноогоор;
- 8.3.6 Удирдах зөвлөлийн гишүүд санал нэгтгэйгээр санг татан буулгах тогтоолд заасан огноогоор;
- 8.4 Гишүүнчлэлийн хугацаа дуусгавар болсон өдрөөр Ерөнхий нөхцөл, Хуримтлал буцаан олгох журам, Гишүүн байгууллагын хамтран ажиллах гэрээ, Тэтгэврийн хуримтлалын гэрээнд заасны дагуу гишүүнд олгох хуримтлалыг тооцоолж, дансыг хааж, гишүүнийг бүртгэлээс хассаны дараа ногдох хуримтлалыг олгоно.

* * *